

**Mongolian language for foreigners – Week 6**  
**Lecture №6**

**Сэдэв: Монголчуудын ном, хэвлэл**  
**Topic: Mongolian books and publications,**  
**The Secret History Mongols**

**Сонсох, ярих, унших, бичих чадварыг дээшлүүлэх**  
**listening, speaking, reading, writing**

**Mongolian National University Arts and Culture**  
**Professor, Basbish.S**

## Хичээлийн агуулга - Lecture content

---

1. Өмнөх хичээлийн бататгал- Reviewing pervious learning
2. Монголчуудын ном, хэвлэл-Монголын нууц товчоо-Mongolian books and publications, The Secret History Mongols
3. Дасгал ажлууд- Exercises
4. Шинэ үг хэллэгүүд- New words
5. Гэрийн даалгавар - Homework

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар  
Reviewing pervious learning and homework

Мэдлэг шалгах тест - Test

1. Дөрвөлжин бичиг ..... онд зохиогдсон.

А. 1260-аад                      б. 1160-аад                      в. 1220-оод                      г. 1350-аад

2. Али гали цагаан толгой нь ..... онд зохиогдсон.

А. 1587                      б. 1206                      в. 1227                      г. 1650

3. Тод үсэг ..... онд зохиогдсон.

А. 1610                      б. 1630                      в. 1750                       г. 1648

4. Соёмбо үсэг ..... онд зохиогдсон.

А. 1686                      б. 1630                      в. 1750                      г. 1648

5. Вагиндрагийн үсэг ..... онд зохиогдсон.

А. 1911                       б. 1905                      в. 1921                      г. 1945

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар  
Reviewing pervious learning and homework

Мэдлэг шалгах тест - Test

1. Монгол бичгийг YII-YIII зууны үед .....улсаас авч хэрэглэсэн гэж үздэг.

а. Төвөд                                   **б.** Согд                                    в. Орос                                    г. Хятад

2. Монгол бичгээр бичсэн хамгийн эртний дурсгал нь “.....” хэмээх гэрэл хөшөөний таван мөр бичээс юм.

а. Мэргэд гарахын орон            б. Монголын нууц товчоо            **в.** Чингисийн чулууны бичиг            г. Тоньюкукийн бичиг

3. Латин үсэг нь .....оны үед Монгол улсад түр хэрэглэгдэж байв.

а. 1940-1950-аад                    **б.** 1930-1940-өөд                    в. 1910-1920-оод                    г. 1920-1930-аад

4. Кирилл үсгийн цагаан толгойд ....., .....үсгүүдийг нэмж, 35 үсэгтэйгээр баталсан.

**а.** Ө,Ү                                    б. О,У                                    в. Й,Ы                                    г. Ъ,Ъ

5. Шинэ үсгийн анхны дүрмийг 1942 онд эрдэмтэн .....зохиожээ.

а. Б.Ринчэн                            б. Б.Явуухулан                            в. Чой.Лувсанжав                            **г.** Ц.Дамдинсүрэн

*Дасгал 1. Асуултыг уншаарай. - Read the questions.*

1. Дэлхийн анхны ном хэзээ хэвлэгдсэн бэ?
2. Монголчууд анх хэзээ хэвлэмэл ном бүтээсэн бэ?
3. Монголчууд эрт үед яаж ном бүтээдэг байсан бэ?
4. Монголчуудын хамгийн алдартай бичгийн дурсгал юу вэ?



(Мөнхцэцэг, Г., Орхон, Б., 2021, хууд. 55)

Номын баяр [Photograph]. (2021, June 11). <https://www.polit.mn/a/90018>

Монголчуудын ном, хэвлэл-Монголын нууц товчоо  
Mongolian books and publications, The Secret History Mongols

---

*Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.  
Memorize the new vocabularies and understand the meaning*

1. Алт- gold
2. Ангилах – to classify
3. Бар /барлах/ хэвлэх- printing, /to print/
4. Баринтаг – a piece of silk or cloth used to wrap sutras
5. Бахархал – the fact
6. Бийрийн бичмэл – manuscript written with pencil brush
7. Бичиг баримт - document
8. Боть - volume
9. Бэх - ink
10. Гар бичмэл - manuscript
11. Даавуу - cloth
12. Дэвтэрлэх – to bind together /book/
13. Нийтлэх – to publish
14. Нугалбар – folded book
15. Нугалж эвхэх – to fold
16. Өвөг дээдэс - ancestor
17. Өгүүлэх – to say
18. Сийлбэрлэх – to engrave
19. Судалгааны бүтээл – research paper
20. Судар- sutra

Монголчуудын ном, хэвлэл-Монголын нууц товчоо  
Mongolian books and publications, The Secret History Mongols

---

*Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.  
Memorize the new vocabularies and understand the meaning*

11. Сударчилсан – made like sutras
12. Сэцэн – wise
13. Цацагтай уяа – string or strap with fringe
14. Тив – continent
15. Торго - silk
16. Түүхийн - historical
17. Тэмдэглэх – to note
18. Урлах – to craft
19. Уях – to tie
20. Хадгалах – to keep
21. Хосгүй - unique
22. Хөшөө - monument
23. Хуйлах – to scroll
24. Хуйлмал - scroll
25. Хуудас - page
26. Үнэт - valuable
27. Үдэх – to bind
28. Үндэсний номын сан – National Library
29. Эрдэнэ - treasure

## Монголчуудын ном, хэвлэл-Монголын нууц товчоо Mongolian books and publications, The Secret History Mongols

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.*


*Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс: Choose from following words: Хатгаж, салангид, хэвлэжээ, нааж, модон бараар, нийлүүлэн, бичиг баримтаа, түүхийн, судар, Монголын нууц товчоо, бахархал, өвөг дээдсээс, хосгүй, судалгааны бүтээл*

### Монголчуудын ном

Европ тивд анх 1445 онд Германы Иоганн Гүттенберг гэдэг хүн Библийн судрыг латин хэлээр 1) хэвлэжээ. Мөн Орост анх 1564 онд Иван Федоров христосын шашны “Апостол” судрыг хэвлэсэн.

Харин дорно дахины ард түмнүүд, ялангуяа Хятад улс нэн эртнээс ном бичиж хэвлэж иржээ. Монголчууд ч эрт дээр үеэс ном бичиж, хэвлэж байсан түүхтэй. Тухайлбал 1311 онд 330 гаруй нүүр “Бодичиръяаватарагийн тайлбар” хэмээх номыг 1000 ширхэг 2) модон бараар хэвлэжээ.



Хүүхдийн ном [Photograph]. (2015, June 30).  
<https://ikon.mn/n/i5a>

## Монголчуудын ном, хэвлэл-Монголын нууц товчоо Mongolian books and publications, The Secret History Mongols

*Нөхөх үгс: Choose from following words: Хамгаж, салангид хэвлэжээ, нааж, модон бараар, нийлүүлэн, бичиг баримтаа, түүхийн, судар, Монголын нууц товчоо, бахархал, өвөг дээдсээс, хосгүй, судалгааны бүтээл*

### Монголчуудын ном

**Монгол номын хэлбэр:** Монголчуудын бичиж, хэвлэсэн номууд хэлбэрийн хувьд чулуун ном, сударчилсан ном, дэвтэрлэсэн ном, нугалбар ном, хуйлмал ном гэх мэт маш олон янз.

**Чулуун ном.** Монголчууд эрт дээр үеэс хад чулуу сийлбэрлэн түүхийн 3) \_\_\_\_\_ тэмдэглэж ирсэн. Хамгийн эртний Монгол бичигтэй хөшөөнүүд бол 1225 онд босгосон “Чингисийн чулуу”, 1257 онд Мөнх хаанд зориулан босгосон бичигт хөшөө юм. Мөн МЭ-ний YI-YIII зууны үеийн Культегиний гэрэлт хөшөө, Билгэ хааны, Тоньюкукийн гэрэлт хөшөө гэх мэт эртний түрэг бичигтэй хөшөө олон бий.

(Мөнхцэцэг, Г., Орхон, Б., 2021, хууд. 55)



Чингисийн чулууны бичиг [Photograph]. (2018, May 11). <https://news.mn/r/778273/>

## Монголчуудын ном, хэвлэл-Монголын нууц товчоо Mongolian books and publications, The Secret History Mongols

*Нөхөх үгс: Choose from following words: Хамгаж, салангид хэвлэжээ, нааж, модон бараар, нийлүүлэн, бичиг баримтаа, түүхийн, судар, Монголын нууц товчоо, бахархал, өвөг дээдсээс, хосгүй, судалгааны бүтээл*

### Монголчуудын ном

**Сударчилсан ном.** Хуудсуудыг нь үдээгүй, 4) \_\_\_\_\_ хэвлэсэн, эсвэл бичсэн номыг сударчилсан ном гэнэ. Ийм номыг баринтагт боож, эсвэл модон шоголд хийж хадгалдаг.

**Дэвтэрлэсэн ном.** Номын хуудаснуудын зүүн гар талын ирмэгүүдийг 5) \_\_\_\_\_ үдсэн ном. Монгол үсгээр бичиж дэвтэрлэсэн ном манай улсын Үндэсний номын санд олон бий. Эдгээрийн хамгийн том нь “Юань улсын 6) \_\_\_\_\_”. Энэ нь 210 дэвтэр бийрийн бичмэл ном. Мөн төвд хэлээр бэх, алт, эрдэнээр бичсэн “Ганжуур”, “Данжуур” хэмээх олон зуун боть судрууд байдаг.

(Мөнхцэцэг,Г.,Орхон,Б, 2021, хууд. 55)



Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйл [Photograph]. (2020, December 24). <https://beta.gogo.mn/r/k5v2y>



Судар бичиг [Photograph]. (2021, September 20). <https://montsame.mn/en/read/275613>

## Монголчуудын ном, хэвлэл-Монголын нууц товчоо Mongolian books and publications, The Secret History Mongols

*Нөхөх үгс: Choose from following words: Хатгаж, салангид хэвлэжээ, нааж, модон бараар, нийлүүлэн, бичиг баримтаа, түүхийн, судар, Монголын нууц товчоо, бахархал, өвөг дээдсээс, хосгүй, судалгааны бүтээл*

### Монголчуудын ном

**Нугалбар ном.** Номоо урт, нарийн цаасан дээр хэвлэж, эсвэл бичээд, нугалж эвхсэнийг нугалбар ном гэдэг. Үүнийг ижил хэмжээний цаасан дээр бичиж, эсвэл хэвлээд дараа нь хуудаснуудаа дэс дараагаар нь залган 7) \_\_\_\_\_ хийдэг байжээ.



(Мөнхцэцэг, Г., Орхон, Б., 2021, хууд. 56)

Судар бичиг [Photograph]. (2021, September 20). <https://montsame.mn/en/read/275613>

## Монголчуудын ном, хэвлэл-Монголын нууц товчоо Mongolian books and publications, The Secret History Mongols

---

*Нөхөх үгс: Choose from following words: Хатгаж, салангид хэвлэжээ, нааж, модон бараар, нийлүүлэн, бичиг баримтаа, түүхийн, судар, Монголын нууц товчоо, бахархал, өвөг дээдсээс, хосгүй, судалгааны бүтээл*

### Монголчуудын ном

**Хуйлмал ном.** Нүүдэлчдийн ахуй амьдралд хэрэглэх, хадгалахад маш тохиромжтой хэлбэр. Ийм номыг ижил хэмжээтэй цааснууд дээр бичиж, хуудаснуудаа дэс дараагаар нь нааж, номын эхлэл, төгсгөл хоёр үзүүрт цаасныхаа өргөнөөс урт нарийн мод тогтоож хийдэг байжээ. Уг 2 модонд номоо хуйлсны дараа хоёр модоо нийлүүлж, цацагтай уяагаар уяж хадгалдаг. Монголын Үндэсний номын санд 1662 онд Саган сэцэний зохиосон “Эрдэнийн товч” хэмээх монголын 8) \_\_\_\_\_ номыг цаасан дээр хар бэх, бийрээр бичсэн 21 см өргөн, 71 м урт гар бичмэл хадгалагдаж байна.



## Монголчуудын ном, хэвлэл-Монголын нууц товчоо Mongolian books and publications, The Secret History Mongols

*Нөхөх үгс: Choose from following words: Хатгаж, салангид хэвлэжээ, нааж, модон бараар, нийлүүлэн, бичиг баримтаа, түүхийн, судар, Монголын нууц товчоо, бахархал, өвөг дээдсээс, хосгүй, судалгааны бүтээл*

### Монголчуудын ном

Өөр материал дээр бичсэн ном бас байдаг. Тухайлбал, цэвэр мөнгөн хуудсан дээр алтаар бичсэн Сандуйн жүд судар. Үүнийг XIX зууны эхээр урласан бөгөөд энэ ном 222 хуудастай, 1460 лан буюу 52 кг 560 г цэвэр алт, мөнгө орсон гэдэг.

Мөн торго, даавуун дээр өнгийн торгон утсаар 9) \_\_\_\_\_ бүтээсэн ном, номын баринтаг, гэх мэт олон бүтээл бий.

Мөн бичсэн зүйлээр нь барын ном, бичмэл ном хэмээн ангилна.

(Мөнхцэцэг,Г.,Орхон,Б, 2021, хууд. 56)



Мөнгөн сандуйн жүд [Photograph]. (2022, November 17).  
<https://nationallibrary.mn/mungun-sanduin-jud/>



Монголын нууц товчоо -торгон судар [Photograph]. (2019, October 12).  
<https://www.polit.mn/a/72519>



## Монголчуудын ном, хэвлэл-Монголын нууц товчоо Mongolian books and publications, The Secret History Mongols

*Нөхөх үгс: Choose from following words: Хамгаж, салангид хэвлэжээ, нааж, модон бараар, нийлүүлэн, бичиг баримтаа, түүхийн, судар, Монголын нууц товчоо, бахархал, өвөг дээдсээс, хосгүй, судалгааны бүтээл*

### Монголчуудын ном

**Барласан номыг** дотор нь модон барын, зэс барын, чулуун барын ном гэх мэтээр юугаар бар хийж хэвлэснээр нь ангилдаг. Эдгээрээс хамгийн эртний бөгөөд түгээмэл хэрэглэдэг нь модон бар юм.



Модон барын ном [Photograph]. (2017, May 5).  
<https://gogo.mn/r/mm8yw>

**Бичмэл номыг** дотор нь модон үзгийн бичмэл, хулсан үзгийн бичмэл, бийрийн бичмэл хэмээн ангилдаг. Мөн бэхээр, алтаар, эрдэнээр бичсэн ном хэмээн ангилдаг.



Зэс барын Жадамба [Photograph]. (2023, March 27). <https://nationallibrary.mn/%d0%b7%d1%8d%d1%81-%d0%b1%d0%b0%d1%80%d1%8b%d0%bd-%d0%b6%d0%b0%d0%b4%d0%b0%d0%bc%d0%b1%d0%b0-%d1%81%d1%83%d0%b4%d0%b0%d1%80/>

(Мөнхцэцэг,Г.,Орхон,Б, 2021, хууд. 56)





# Монголчуудын ном, хэвлэл-Монголын нууц товчоо Mongolian books and publications, The Secret History Mongols

**Нөхөх үгс:** Choose from following words: *Хатгаж, салангид хэвлэжээ, нааж, модон бараар, нийлүүлэн, бичиг баримтаа, түүхийн, судар, Монголын нууц товчоо, бахархал, өвөг дээдсээс, хосгүй, судалгааны бүтээл*


## Монголын нууц товчоо

Үндэстэн бүхэнд 10) \_\_\_\_\_ болсон ном зохиол байдаг. Монгол үндэстний хувьд түүх, уран зохиол, хэл шинжлэлийн хосгүй үнэт дурсгал бол “Монголын нууц товчоо” юм. Монголын нууц товчоог зохиосон хүний нэр өнөөг хүртэл мэдэгдээгүй. Үүнийг 1240 онд зохиогдсон гэж үздэг. Нийт 12 бүлэгтэй. Үүний эхний 10 бүлэгт Чингис хааны 11) \_\_\_\_\_ эхлээд нас барах үе хүртэл болсон үйл явдлуудыг өгүүлсэн. Дараагийн 2 бүлэгт Өгөөдэй хааны үеийн үйл явдлыг бичжээ.

(Мөнхцэцэг,Г.,Орхон,Б, 2021, хууд. 50)



Монголын нууц товчоо [Photograph]. (2015, July 24). <https://www.arslan.mn/lifestyle/advice/23930.shtml>



Монголын нууц товчоо [Photograph]. (2019, April 15). <https://montsame.mn/en/read/186169>



Монголын нууц товчоо [Photograph]. (2019, November 17). <https://www.mnb.mn/i/192625>



Монголын нууц товчоо [Photograph]. (2020, November 16). <https://www.mnb.mn/i/222551>

Монголчуудын ном, хэвлэл-Монголын нууц товчоо  
Mongolian books and publications, The Secret History Mongols

---

*Нөхөх үгс: Choose from following words: Хатгаж, салангид хэвлэжээ, нааж, модон бараар, нийлүүлэн, бичиг баримтаа, түүхийн, судар, Монголын нууц товчоо, бахархал, өвөг дээдсээс, хосгүй, судалгааны бүтээл*

МНТ бол XIII зууны үеийн Их монгол улсын үед Монгол оронд болсон явдлуудыг үнэнээр нь бичсэн учраас түүхийн 12) \_\_\_\_\_ баримт болсон. МНТ -г Монгол хүн Монгол газар зохиосон тул гадаадын түүхч нарын зохиолоос их ялгаатай.

МНТ-г орос, герман, япон, франц, чех, турк, англи, унгар, польш, казак, халимаг, тува зэрэг олон хэлээр орчуулан хэвлэсэн. МНТ-ны талаар 1000 гаруй 13) \_\_\_\_\_ нийтлэгдсэн.

Монголчуудын ном, хэвлэл-Монголын нууц товчоо  
Mongolian books and publications, The Secret History Mongols

---

***Дасгал 3. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.  
Exercise 3. Discuss about following questions and review your understanding***

1. Европт анх хэзээ ном хэвлэсэн бэ?
2. Монголчууд 1311 онд ямар ном хэдэн ширхэг хэвлэсэн бэ?
3. Чулуун ном гэж юу вэ? Яаж бүтээдэг вэ?
4. Сударчилсан ном гэж юу вэ? Яаж бүтээдэг вэ?
5. Дэвтэрлэсэн ном гэж юу вэ? Яаж бүтээдэг вэ?
6. Нугалбар ном гэж юу вэ? Яаж бүтээдэг вэ?
7. Хуйлмал ном гэж юу вэ? Яаж бүтээдэг вэ?
8. Ном барлах гэж юу вэ? Ямар ямар бар байсан бэ?
9. Монголчууд бичмэл номыг юу юугаар бичдэг байсан бэ? Өөр юу юугаар ном бүтээдэг байсан бэ?
10. Монголын нууц товчоо хэдэн онд зохиогдсон бэ? Юуны тухай ном бэ?

Монголчуудын ном, хэвлэл-Монголын нууц товчоо  
Mongolian books and publications, The Secret History Mongols

**Дасгал 4. А. Өгөгдсөн үгсээр холбоо үг үүсгэнэ үү.**  
**Exercise 4. A. Match following words to its explanation.**

- |              |              |
|--------------|--------------|
| 1. Шүлэг     | а. редактор  |
| 2. Хэвлэлийн | б. болох     |
| 3. Зохиолч   | в. тэмдэглэл |
| 4. Номын     | г. зохиол    |
| 5. Сонсдог   | д. ном       |
| 6. Жүжгийн   | е. бичих     |
| 7. Түүхийн   | ё. боть      |
- 

1..... 2..... 3..... 4..... 5..... 6..... 7.....

Монголчуудын ном, хэвлэл-Монголын нууц товчоо  
Mongolian books and publications, The Secret History Mongols

---

**Дасгал 4. Б. Дээрх үгсийг ашиглан өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү.**  
**Exercise 4. B. Complete the sentence using above words**

1. Сайн .....**зохиолч болох**..... ганц л арга бий. Тэр нь ном их унших.
2. .... нь бичвэрийг хянах, засах ажлыг гүйцэтгэдэг.
3. Бэгзийн Явуухулан 1964 онд “Би хаана төрөө вэ?” .....
4. ....-даа/дээ номын нэр болон төрөл зохиолчийн тухай мэдээлэл, хэвлэгдсэн он зэргийг заавал бичээрэй.
5. ....-ийг/ыг та гар утас, таблет, компьютер зэргээр сонсож болно.
6. Монголын эзэнт гүрний ..... (5)-ийг/ыг 2019 онд хэвлэжээ.
7. У.Шекспирийн “Ромео Жульетта” .....-ийг/ыг Ч.Чимэд, Х.Мэргэн нар орчуулсан.





Мэдлэг шалгах тест - Test

1. Европ тивд анх .....онд Германы Иоганн Гүттенберг гэдэг хүн Библийн судрыг латин хэлээр хэвлэжээ.

а. 1445

б. 1450

в. 1540

г. 1545

2. 1311 онд 330 гаруй нүүр “Бодичаримаватарагийн тайлбар” хэмээх номыг 1000 ширхэг .....  
.....ХЭВЛЭЖЭЭ.

а. төмөр бараар

б. модон бараар

в. зэс бараар

г. чулуун бараар

3. Хамгийн эртний монгол бичигтэй хөшөө бол 1225 онд босгосон “.....” юм.

а. Тоньюкукийн хөшөө

б. Билгэ хааны хөшөө

в. Культегиний хөшөө

г. Чингисийн чулуу

4. Хуудсуудыг нь үдээгүй, салангид хэвлэсэн эсвэл бичсэн номыг .....НОМ ГЭНЭ.

а. Нугалбар

б. Хуйлмал

в. сударчилсан

г. дэвтэрлэсэн

5. Номын хуудаснуудын зүүн гар талын ирмэгүүдийг нааж үдсэн номыг .....НОМ ГЭНЭ.

а. Нугалбар

б. Хуйлмал

в. сударчилсан

г. дэвтэрлэсэн



## Гэрийн даалгавар 2 Homework 2



<https://thenounproject.com/icon/homework-3841940/>

- *Сэдэвт гарсан шинэ үг хэллэгүүдийг цээжлээрэй.  
Memorize vocabulary in the given topic*
- *Өөрийн ном, хэвлэлийн талаар бичнэ үү.  
Write about the books and publications of your country*

## НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

### Ном зүй

Мөнхцэцэг,Г.,Орхон,Б. (2021). Монгол орон судлал. Улаанбаатар: Линограф ХХК.

Цэвэл,Я. (2021). Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар: МУИС Пресс ХХК.

Номын баяр [Photograph]. (2021, June 11).

<https://www.polit.mn/a/90018>

Хүүхдийн ном [Photograph]. (2015, June 30).

<https://ikon.mn/n/i5a>

Чингисийн чулууны бичиг [Photograph]. (2018, May 11).

<https://news.mn/r/778273/>

Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйл [Photograph]. (2020, December 24).

<https://beta.gogo.mn/r/k5v2y>

Судар бичиг [Photograph]. (2021, September 20).

<https://montsame.mn/en/read/275613>

Эрдэнийн товч-Хуйлмал [Photograph]. (2022, November 25).

<https://nationallibrary.mn/erdeniin-tovch-khuilmal/>

Мөнгөн сандуйн жүд [Photograph]. (2022, November 17).

<https://nationallibrary.mn/mungun-sanduin-jud/>

Монголын нууц товчоо -торгон судар [Photograph]. (2019, October 12).

<https://www.polit.mn/a/72519>

## НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

---

Мөнгөн Сандуйн жүд [Photograph]. (2022, November 17).

<https://nationallibrary.mn/mungun-sanduin-jud/>

Модон барын ном [Photograph]. (2017, May 5).

<https://gogo.mn/r/mm8yw>

Зэс барын Жадамба [Photograph]. (2023, March 27).

<https://nationallibrary.mn/%d0%b7%d1%8d%d1%81-%d0%b1%d0%b0%d1%80%d1%8b%d0%bd-%d0%b6%d0%b0%d0%b4%d0%b0%d0%bc%d0%b1%d0%b0-%d1%81%d1%83%d0%b4%d0%b0%d1%80/>

Алтан жадамба [Photograph]. (2022, November 16).

<https://nationallibrary.mn/altan-jadamba-zumbertei/>

Есөн эрдэнийн Жадамба [Photograph]. (2022, November 16).

<https://nationallibrary.mn/yusun-erdeniin-jadamba/>

Монголын нууц товчоо [Photograph]. (2015, July 24).

<https://www.arslan.mn/lifestyle/advice/23930.shtml>

Монголын нууц товчоо [Photograph]. (2019, April 15).

<https://montsame.mn/en/read/186169>

Монголын нууц товчоо [Photograph]. (2019, November 17).

<https://www.mnb.mn/i/192625>

Монголын нууц товчоо [Photograph]. (2020, November 16).


<https://www.mnb.mn/i/222551>

## Анхаарал хандуулсанд баярлалаа

Дараагийн хичээл хүртэл  
баяртай!



[https://www.flaticon.com/free-icon/teacher\\_1995413](https://www.flaticon.com/free-icon/teacher_1995413)



<https://thenounproject.com/icon/lecture-1525984/>